

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

№ 19 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/30

Сүмбэр сум

Хүүхдийг болзошгүй
“Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх”
үйл ажиллагаанд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Захиргааны ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, Хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөрийн 3.1.1.3, 3.1.4.3 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүүхдийг болзошгүй “Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх” үйл ажиллагааны удирдамжийг 1 дүгээр хавсралтаар, төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хүүхдийг болзошгүй “Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх” үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг Гэр бүлийн хөгжил, оролцоо хариуцсан ажилтан /М.Уянга/-д даалгасугай.

3. Үйл ажиллагаанд зарцуулагдах 19 000 /арван есөн мянга/ төгрөгийг үндсэн санхүүжилтийн дансны бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас гаргахыг нягтлан бодогч /Д.Оюунцэцэг/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ц.ОЮУНБИЛЭГ

Д:/Бичиг хэрэг /тушаал

421190048